

АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

THE IMPACTS OF CORRUPTION ON THE NATIONAL SECURITY OF MONGOLIA



Б.ӨНӨРМАА

Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвийн судлаач,
хууль зүйн ухааны доктор

UNURMAA B. (Ph.D.)

Researcher at the Training and Research Center of the Office
of the Prosecutor General of Mongolia

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд судлаач авлигын гэмт хэрэг Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх талаар дурдан дүгнэлт саналаа тусгажээ.

Abstract: In this article the author has discussed about the impacts of corruption on the national security of Mongolia, proposing her own conclusions and ideas about the subject.

Авлига нь төрийн тогтвортой байдал, нийгмийн аюулгүй байдалд аюул занал учруулж ардчилсан тогтолцоо, нийгмийн үнэт зүйлс, ёс суртахууныг үнэгүйдүүлж, хууль дээдлэх ёсыг аажмаар устгаж байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч үүний эсрэг тууштай тэмцэх арга замыг эрэлхийлэх болсны жишээ нь 2003-10-31-нд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас Авлигын эсрэг конвенц баталсан явдал юм. Авлигын цар хүрээ, хор аюул нэг улс үндэсний хэмжээнээс халин гарч бүс нутаг, олон улсын шинжтэй болсон учраас үүнээс өмнө ч авлигатай тэмцэх чиглэлээр олон улсын гэрээ, конвенцүүд батлагдан гарч байсан. Тухайлбал: Авлигын эсрэг конвенц батлагдахаас өмнө Америкийн нэгдсэн улсын байгууллагаас 1996-03-29-ний өдөр “Авлигын эсрэг тэмцэх тухай Америкийн улс хоорондын конвенц”, Европын холбооны зөвлөлөөс 1997-05-26-ны өдөр баталсан “Европын хамтын нийгэмлэгийн албан тушаалтан болон Европын холбооны гишүүн улсын албан тушаалтанд холбогдох авлигатай тэмцэх тухай конвенц”, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 1997-11-21-ний өдөр баталсан “Олон улсын бизнесийн хэлцэлд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдахтай тэмцэх тухай конвенц”, Европын зөвлөлийн Сайд нарын

хорооноос 1999-01-27-ны өдөр баталсан “Авлигын талаарх эрүүгийн эрх зүйн тухай конвенц”-ийг дурдаж болно. Авлига зөвхөн тухайн улс оронд биш хил хязгаар дамжин, зохион байгуулалттай гэмт хэргийн гол суурь хэрэг болж үйлдэгдэж байгааг анхаарч НҮБ-аас баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг” конвенц 2003-09-29-ний өдөр хүчин төгөлдөр болсон юм¹.

2003-10-31-нд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан Авлигын эсрэг конвенцэд Монгол Улс 2005 онд нэгдэн орсноор уг баримт бичгийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн юм.² Авлигын эсрэг конвенцийн үр нөлөө, Монгол Улсын хуульд хэрхэн тусгалаа олсон талаар тодруулахаас өмнө “Авлига” гэдэг нэр томъёоны тухай тодруулах нь зүйтэй болов уу.

Авлига буюу “Korruption” гэдэг үг “corrumpere” гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд энэ нь ялзарч муудах, өнгө зүсээ алдах, ёс суртахууны доройтолд орох гэсэн утгатай ажээ.³ Эртний Египетээс үүсэлтэй улмаар Ромын эзэнт гүрнийг мөхлийн ангал руу түлхсэн авлига гэгч нь түүхийн бүхий л цаг үед хаад ноёд, эрхтэн дархтнуудад тал засах, тэдгээрийн эрх мэдлээ хадгалж үлдэхийн төлөөх ил далд тэмцэлд гол үүрэг гүйцэтгэж ирсэн байна. Платон, Аристотель нар нь тухайн цаг үедээ эрхтэн дархтан, жирийн ард түмний амьдралын ялгаа, төрийн шударга бус хуваарилалт,

¹ Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц

² 2005-10-27-ны өдөр Монгол Улсын Их Хурал уг конвенцийг соёрхон баталсан

³ Unurmaa Byambajav, Die Unrechtsvereinbarung als Kern der Korruptionsdelikte, 2014, S.6; Ueberhofen, Korruption und Bestechungsdelikte im staatlichen Bereich, 2009, S. 30



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

сонгуулийн саналыг худалдах, төрийн эрх мэдлийг өөр хоорондоо наймаалцах аргаар бие биедээ шилжүүлж буй байдал мөн эдийн засгийн тэнцвэргүй байдал буюу баян хоосны ялгааг олж харан энэ тухай өөрсдийн боловсруулсан онол сургаалд тусгаж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.⁴ Монгол Улсын хөгжлийн түүхэнд ч авлига хар мөрөө үлдээсэн нь манжийн дарлалд нухлагдсан бараан цаг үед түшмэд ноёд эрх мэдлийн төлөө манжийн хаанд тал засаж эмс охидоо бэлэглэн өргөл барьц өгөх, манжийн эсрэг тэмцсэн эх орончдоо худалдаж байсан нь мөн Богд хаант Монгол Улсын үед ч дээдэст тал засаж чадсан нь хангалуун амьдардаг байсан зэрэг нь мөн л түүхэнд бичигдсэн байдаг. Дээрх жишээ нь авлига гэгч үүссэн цаг үеэсээ түүхэнд хар мөрөө үлдээж үндэстнийг үгүй хийх хэмжээний хор нөлөөтэйг харуулж байна. Авлига Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлж түгшүүрийн харанга хэдийн дэлдсэнийг олон жишээгээр дурдаж болно.

Монгол Улсын **Үндэсний аюулгүй байдлын тухай хууль**: Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. Мөн «Үндэсний язгуур ашиг сонирхол»-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана⁵ гэж заасан байдаг.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрдэл хэсгүүдийг

1. Монгол Улсын аюулгүй оршин тогтнохын аюулгүй байдал
2. Эдийн засгийн аюулгүй байдал
3. Нийгэм төрийн аюулгүй байдал
4. Иргэний эрх эрх чөлөөний аюулгүй байдал
5. Шинжлэх ухаан технологийн аюулгүй байдал
6. Мэдээллийн аюулгүй байдал
7. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал
8. Хүн амын удмын сангийн аюулгүй байдал
9. Экологийн аюулгүй байдал юм.

Эдгээр бүрдэл хэсгүүдээс аль нэг алдагдахад үндэсний аюулгүй байдлын тухай

цогц асуудал урган гарч ирнэ. Эдгээрээс Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал өнөөдөр бүрэн хамгаалагдаж чадаж байгаа эсэхийг Авлигын эсрэг конвенцийн зарчим, заалт манай улсын үндэсний хууль тогтоомжид тусгалаа олж хэрэгжиж чадаж байгаа эсэхийг судалгаа болон холбогдох хуулийн заалтыг үндэслэн та бүхэнд харуулахыг зорилоо. Харьцуулалт хийхийн өмнө та бүхнийг Транспэрэнси Интернешнл олон улсын байгууллагаас жил бүр авлигын индексийг судлан зарладаг судалгааны дүнд анхаарлаа хандуулахыг хүсэж байна. Уг судалгааны үр дүнгээс харахад 1999 онд Монгол Улс 99 орноос 49 дүгээр байранд буюу дундаж үзүүлэлттэй байсан бол 2005 онд 158 орноос 85 дугаар байранд 2012 онд 174 орноос 94 дүгээр байранд орж үзүүлэлт нэлээд олон нэгжээр доошилж 2013 онд 175 орноос 83, 2014 онд 174 орноос 80 дугаар байранд орсон үзүүлэлттэй байна.⁶ Авлигын нөхцөл байдлын индексийн дагуу 10 оноо авах ёстойгоос /авлигагүй бол/ дөнгөж 3.0 оноо авч байгааг тооцвол авлигын нөхцөл байдал манай улсад даамжран хүндрэх чиглэлтэйг харуулж байна.

Авлига цэцэглэх хамгийн таатай боломж хөрс бол байгалийн баялагтай, техник технологийн хувьд хараат, хөгжингүй буурай орнууд гэдгийг түүх нэгэнт баталсан, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн мөн үндэсний аюулгүй байдал нь байгалийн баялгийн аюулгүй байдлаас ихээхэн хамаарах болсон энэ үед Монгол Улсын нүүрс, алт, зэс, молибден зэрэг байгалийн баялгийн асар их нөөц нь дэлхийн өндөр хөгжилтэй орнууд үндэстэн дамнасан корпорациудын сонирхлыг ихээхэн татаж хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй удаан хугацааны гэх чимэг зүүлт зүүсэн зээл, тусламж, амлалт ар араасаа цуварч үүнтэй холбоотойгоор Монгол Улсад хийж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт жил ирэх бүр нэмэгдэж байгаа бөгөөд 85 гаруй хувь нь уул уурхайн салбарт хийгдэж байна.⁷

Байгалийн баялгаа түшиглэж хөгжих сонирхолд тулгуурлан хөрөнгө оруулагчдыг татах нэрээр хөрөнгө оруулалтын өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр өөрт ашигтай хууль, шийдвэр гаргуулахын тулд эрх мэдэлтнүүдийн хахуульдах, үндэсний хууль тогтоомжид буй хуулийн цоорхойг ашиглах, аливаа нам, бүлэглэлийн сонгуульд хандив өгөх, авлигын хамгийн далд хэлбэр болох давуу талууд буюу хувь хүртээх, үнэт цаасны

⁴ Walter de Gruyter Theologische Enzyklopedie, Teil 1, Band 1 - Teil 2, Band 27

⁵ Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын тухай хууль

⁶ <https://www.transparency.de/Corruption-Perceptions-Index-2.2569.0.html>

⁷ www.invest.mn/mgluurhai.html



зах зээлд авлигын замаар өгсөн авсан хувьцааг борлуулж дүрсийг хувиргах зэрэг авлигын нөгөө тал мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж улмаар эдийн засгийн эрүүл бодлого алдагдсан олон улсуудын гашуун түүхийг давтахгүй байх боломж манай улсад бий.

Авлигатай тэмцэх гол суурь нь төрийн зөв бодлого, шударга улс төрчид, цоорхойгүй хууль, тэгш хяналт, хуулийн байгууллагын улс төрөөс ангид хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломж гэх мэтчилэн олон хүчин зүйл байдаг.

Эдгээрээс өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гол хууль амьдралд нийцэхгүй, олон улсын гэрээ конвенцийн шаардлагыг хангахгүй байгаа нь харамсалтай.

Тухайлбал манай улсын Эрүүгийн хуульд байгаа шан харамж болон хээл хахуультай холбоотой заалтууд 2003-10-31-нд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан Авлигын эсрэг конвенцтэй⁸ харьцуулахад хэт явцуу байна. Уг конвенцийн 16 дугаар зүйлд гадаадын төрийн албан тушаалтан болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах үйлдлийг гэмт хэрэгт тооцох тухай мөн 21 дүгээр зүйлд хувийн хэвшил дэх авлигыг гэмт хэрэгт тооцох тухай заасан боловч дээрх заалтууд Монгол Улсын Эрүүгийн хуульд бүрэн утгаараа тусгалаа олоогүй өнөөдрийг хүрчээ. Ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт хийх зөвшөөрөл, байгалийн баялгийг өөр бусад хэлбэрээр зарж борлуулах зөвшөөрөл олгох эрх уг чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага албан тушаалтны хувьд онцгой чиг үүрэг юм. Тусгай эрх олгох албан тушаалтан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд болон шууд бусаар зүй бус давуу тал олгох зорилгоор чиг үүрэг, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, аливаа үйлдлийг хууль тогтоомж зөрчин гүйцэтгэх эсхүл гүйцэтгэхгүй байх үйлдлийг гэмт хэрэгт тооцож байхыг НҮБ-ын конвенцийн 19 дүгээр зүйлд оролцогч улс бүрд үүрэг болгожээ. Алгын чинээ цаасан дээрх гарын үсэг араасаа хэдэн арван сая, тэрбум төгрөгөөр тооцогдох шан харамж, хахуулийн хардлага нийгэмд төрүүлж байгаа нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль тогтоомжийн заалтад дүгнэлт хийхэд зарим талаар үндэслэлтэй байж болох өөрөөр хэлбэл албан тушаалтанд ашигтай ч байж болох зүйл анги байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй байна. Тухайлбал

⁸ Авлигын эсрэг НҮБ-ын конвенц

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 170 дугаар зүйлд "тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан албан үүргийн дагуу ажил гүйцэтгэж үйлчилгээ үзүүлэх үүргээ далимдуулан хясан боогдуулах замаар удаа дараа буюу их хэмжээний шан харамж авсан нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...."⁹ гэж заасан нь учир дутагдалтай байна. Дээрх хуулийн заалтаар нэг удаа бага бус эсхүл үлэмж хэмжээний шан харамж авсан бол захиргааны хариуцлага хүлээж их хэмжээний шан харамж авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа нь шударга бус юм.

Хууль тогтоогч авлигын хамгийн түгээмэл хэлбэр болох шан харамжийн авч болох хэмжээг тогтоон дээрх субъектүүдийг "их" хэмжээтэй л биш бол тодорхой хэмжээгээр албан тушаалаа ашиглан "боломжийн орлого" олж амьдралаа дээшлүүлэхийг хуулиар "зөвшөөрснийг" төрөөс бэлэглэсэн бэлэг гэж үзэхээс өөр яах билээ. Авлигын хамгийн түгээмэл хэрэг болох шан харамжийн заалтыг хэт явцуу тодорхойлж, хүлээлгэж болох ял шийтгэлийн хэмжээг "толгой илэх" хэмжээнд тогтоон шан харамжийн хэргийг авлигын гэмт хэргийн төрөлд биш аж ахуйн эсрэг гэмт хэргийг бүлэгт оруулсан нь конвенцийн агуулга зарчимтай харшилж байна.

Чанаргүй барилга, зам ашиглалтад оруулах зөвшөөрөл олгох, хилээр хууль бус зүйл, их хэмжээний мөнгө зэргийг "анзааралгүй" оруулах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийг "сануулсан" болоод өнгөрөх цаашилбал тендер нэрийн доор хууль бус сонгон шалгаруулалт явуулах, төрийн тусгай хамгаалалттай газар барилга барих зөвшөөрөл олгох, цаасан дээр монгол хүний нэр бичигдэж цаанаа гаднын эзэнтэй аж ахуйн нэгжид тогтоосон хуль, дүрэм зөрчин уул уурхай, хайгуул, олборлолтын зөвшөөрөл г.м тусгай зөвшөөрөл олгох гэх мэт жагсаалт хөвөрнө. Түүнчлэн их хэмжээний шан харамж гэдгийг хэдэн төгрөгөөр тооцох тухай Эрүүгийн хуульд байдаггүй ба зөвхөн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яаж тооцохыг Эрүүгийн

⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль



金剛般若經

хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд зохицуулсан байдаг. Практикт дээрх заалтыг барин хээл хахуулийн хэмжээг тооцож байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар зүйлд заасан хууль ёсны зарчмыг зөрчиж байна. Мөн 192,000 төгрөгийн эд зүйл хулгайлсан иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь дээрх хуулийн заалттай харьцуулахад Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчим зөрчигдөж байгааг харуулж буй бодит жишээ юм.

НҮБ-ын конвенцийн 15 дугаар зүйлд нийтийн албан тушаалтан эрхэлж буй ажлаа ашиглан аливаа давуу тал олж авсан үйлдэл эс үйлдэл болгоныг гэмт хэрэгт тооцохоор заасан боловч Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид энэ заалт өнөөдрийг хүртэл тусгалаа олоогүй байна. Тодруулбал хээл хахуулийн гэмт хэргийн объектив талын бүрэлдэхүүнийг ...*Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс* албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр..... гэсэн ерөнхий үйлдлээр хязгаарласан нь өндөр түвшний авлигыг илрүүлэх боломжгүй болгож хууль ёсны дагуу шийдвэр гаргаж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлснийхээ төлөө хахууль, шан харамж, эдийн болон эдийн бус давуу тал олж буй этгээдүүдэд ял завшуулах боломжийг бүрдүүлж байна. Дээрх заалтаар өндөр түвшний буюу бодлогын түвшинд үйлдэгдэж буй авлигын гэмт хэргийг шалгах боломжгүй бөгөөд ялангуяа өндөр албан тушаалтан эрхэлж буй албан тушаалын нөлөөгөө ашиглаж олсон эдийн болон эдийн бус давуу талууд гэмт хэрэгт тооцогдохгүй байгаа нь шударга бус бөгөөд авлигын эсрэг манай улс бүрэн тэмцэж чадахгүй байгааг харуулж буй бодит жишээ юм. НҮБ-ын конвенцийн 15 дугаар зүйлд нийтийн албан тушаалтан эрхэлж буй ажлаа ашиглан аливаа давуу тал олж авсан үйлдэл эс үйлдэл болгоныг гэмт хэрэгт тооцохоор үүрэг болгосныг дурдах нь зүйтэй болов уу.

Олон улсын санхүүжилт эсхүл корпораци, компани тухайн улс оронд үйл ажиллагаа явуулахын тулд олон шатлалтай, тусгай шалгуурыг давсан байж тусгай зөвшөөрөл авдаг. Уг зөвшөөрөл хамтын зарчмаар шийдэгдэх буюу зөвхөн нэг эрх мэдэлтний зөвшөөрлөөр олгогдох боломжгүй байдаг бөгөөд боломжгүй зөвшөөрлийг боломжтой болох нэг хар зам нь өндөр түвшний авлига юм. Өндөр түвшний авлига гэдэг

нь хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах түвшинд бусдад давуу тал олгох эсхүл хууль бус нөлөөллийг хамтын шийдвэр нэрийн доор баталгаажуулах үүний үр дүнд удаан хугацааны туршид эсхүл зохион байгуулалттайгаар хууль бус ашиг, эдийн болон эдийн бус давуу тал олох бусдад олгох бүхий л хэлбэрийг хэлдэг.¹⁰ Авлигын илрэх хэлбэрийг олон улсад 2 янзаар ангилдаг.

☐ Petty Corruption/Situative Korruption/ - тохиолдлын буюу нэг удаагийн, илрүүлж шалгаж тогтооход хялбар, албан хаагчид ихэвчлэн өртдөг, авсан авлигын хэмжээ бага буюу хууль бусаар олсон хөрөнгө, давуу талыг тогтоох боломжтой

■ Grand Corruption/Структурелле Коррупция/ : Өндөр түвшний буюу төрийн болон олон улсын байгууллагын өндөр албан тушаалтан , томоохон аж ахуйн нэгж оролцсон, улс төрийн нөлөө, хууль бус лоббигоор дамжиж эсхүл тодорхой бизнесийг далд аргаар дэмжихэд чиглэгдсэн, авлигын төрөл нь ихэвчлэн үнэт цаас, хөрөнгө оруулалт, хөнгөлөлт, давуу тал байдаг бөгөөд хууль бусаар олсон зүйлийг эдийн засгийн эргэлтэд оруулах буюу мөнгө угаах гэмт хэрэг давхар үйлдэгддэг. Хууль бус харьцаа нь удаан хугацааны эсхүл үргэлжилсэн шинжтэй бөгөөд илрүүлэхэд бэрхшээлтэй байдаг.¹¹

Монгол Улсын эрүүгийн эрх зүйд өндөр түвшний авлигын талаар судлах эх сурвалж, хууль зүйн талаас томьёолсон тодорхойлолт бараг байдаггүй бөгөөд хуульчид эсхүл хууль тогтоогчид үүнд анхаарлаа хандуулахгүй эсхүл конвенцийн агуулга, ач холбогдлыг мэдсэн боловч үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгахгүй цаг алдаж байгаа нь олон талын шалтгаантай гэх хардлагыг төрүүлж байна. Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэх шатанд шүүгч илт хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу тал олгосон үүний төлөө шан харамж, хээл хахууль, давуу тал олсон бол авлигын гэмт хэрэгт тооцогддог практик олон улсад тогтжээ. Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангид дээрх зохицуулалт мөн л бүрхэг байна. Тухайлбал:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим заалтыг жишээ болгон харуулбал:

250.1.Шүүгч шунахайн болон хувийн бусад сэдэлтээр илт хууль бүс шийдвэр

¹⁰ Bannenberg, *Korruption in Deutschland: Portrait einer Wachstumsbranche*, S.33; Internationales Handbuch der Kriminologie, Band 28 S.365

¹¹ Bannenberg, Korruption in Deutschland: Portrait einer Wachstumsbranche, S.33; Internationales Handbuch der Kriminologie, Band 28 S.365, Hoeffling, Korruption als soziale Beziehung, S.32

гаргасан бол.. таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ... гэж заасан.

Шунахайн сэдэлт гэдэг материаллаг буюу эдийн болон эдийн бус давуу тал олж авах хүсэл, сонирхол юм. Хуулийн дээрх заалтад дурдагдсан субъект хээл хахууль авч хуулиар олгогдсон онцгой эрхээ урвуулан шийдвэр гаргасан тохиолдолд шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэгт тооцож байгаа нь буруу бөгөөд дээрх тохиолдолд авлигын эсрэг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр өөрчлөх мөн Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд дээрх субъектүүдийг тусгайлан нэрлэж өгөх шаардлагатай. Германы Эрүүгийн хуулийн тусгай ангийн 331, 332 дугаар зүйлүүдэд дээрх гэмт хэргийн субъектүүдийг албан тушаалтан, нийтийн албан хаагч гэж зааснаас гадна шүүгчийг тусад нь томьёолон заасан байдаг. Учир нь шүүгч шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх онцгой эрхээ урвуулан хээл хахууль авсан, давуу тал олсон бол илүү хүнд ял шийтгэл оногдуулахаар заасан нь үндэслэлтэй. Харин манай улсын Эрүүгийн хуулийн 250 дугаар зүйлийн 250.1, 248 дугаар зүйлийн 248.1-д зааснаар хүлээлгэх хариуцлага буюу оногдуулах ял шийтгэл нь мөн хуулийн 268 дугаар зүйлд зааснаар хүлээлгэх ял шийтгэлтэй харьцуулахад хөнгөн, албан тушаал эрхлэх эрх хасах ялгүй байгаа нь ял завших боломжийг бий болгохоос гадна хуулийн шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.¹²

Тусгай зөвшөөрөл тэр тусмаа байгалийн баялаг ашиглах, олборлохтой холбоотой зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Эрүүгийн хуулийн холбогдох цөөхөн заалттай уялдуулан дүгнэлт хийхэд манай улс НҮБ-ын конвенцийг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүргээ биелүүлээгүй өнөөдрийг хүрчээ. Үндэсний аюулгүй байдлын салшгүй бүрэлдэхүүн болох байгалийн баялгаа бусдад ашиглуулах, эсхүл борлуулах үйл ажиллагаа хуулийн олон талын хамгаалалтад явагдах ёстой. Байгалийн баялагтай холбоотой бизнесийн хөрөнгө оруулалтын хэмжээ хэдэн тэрбумаар тооцогдож байгаа үед хуулийн цоорхой ашиглан Монгол Улсад хууль бус мөнгө урсах боломж хөрс бий болсны анхаарах болжээ.

Авлигын хэрэг шалгах бүрд давхар мөнгө угаах гэмт хэргийг шалгаж хэвших буюу мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульд тодорхой

нэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Авлигын хэрэг ямагт ил далд аргаар үйлдэгдэхээс гадна уг гэмт хэргийг илрэхээс сэргийлэх зорилгоор гэмт этгээдүүд авлигаар авсан зүйл, эдийн болон эдийн бус давуу байдлыг дүрс, хэлбэр, байршил зэргийг нарийн зохион байгуулалттайгаар өөрчилж ингэхийн тулд бусдыг гэмт хэрэгт буюу мөнгө угаах гэмт хэрэгт татан оролцуулах нь олон улсын хэмжээнд төдийгүй манай улсын хар зах зээлд хэдийн байр сууриа олсон байна. Тухайлбал авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хувьцаа үнэт цаасны зах зээлд борлогдох, халхавч болгож үйлдсэн зээлийн гэрээ, зохиомол өр, бусдын нэр дээр авсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө зарагдах, түрээслэх хууль бус бэлэглэлийн гэрээгээр шилжих, аж ахуйн нэгжийн хувьцааг гэр бүл, найз нөхөд гэх мэт өөр хүний нэр дээр эзэмшүүлэн хувь хүртэх, гадаадад дансанд их хэмжээний мөнгө, валют зэргээр мөнгө угаах гэмт хэргийн энгийн элемент агуулагдсан үйлдлүүдэд анхаарлаа хандуулах цаг болжээ. Мөнгө угаах гэмт хэрэг дараах үе шаттай үйлдэгддэг.¹³

1. Placement буюу байршуулах: Эхний үе шатанд хууль бусаар олсон үнэт цаас, мөнгө, эд зүйлс, хувьцаа, бусад эрхийн бичиг гэх мэтийг хаа нэгтээ байршуулдаг. Тухайлбал: Өөр хүний нэр дээр банканд хадгаламж болон харилцах данс нээлгэх, үнэт цаас, чек худалдан авах, алт үнэт зүйлсийг хадгалуулах г.м

2. Layering буюу нуун далдлах үе: Энэ үе шатанд дээр дурдагдсан зүйлсийн гарал үүслийг нь нуун далдлах зорилгоор байршуулсан зүйлээрээ хөрөнгө оруулалт, хандив тусламж, хүүтэй зээл, бусдын нэр дээр объект, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах, асрамжийн болон буяны байгууллага, сан, компани, банк байгуулах, тэдгээрийг даатгуулах зэрэг үйлдэл хийгддэг.

3. Integration буюу эргэлтэд оруулах үе Сүүлийн энэ үе шатанд гарал үүслийг нь нуусан мөнгө бусад зүйлийг хууль ёсны эдийн засгийн эргэлтэд оруулдаг. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хийсэн газраа зарах, түрээслэх замаар ашиг олох, зээлсэн мөнгөнийхөө хүүг авах, компани, сангийн тодорхой хувь эзэмшигч болох гэх мэт. Дээрх үйл явцаас харахад авлигын болон

¹³ Монголд мөнгө угааж байна уу гэсэн нийтлэлээс мөнгө угаах гэмт хэргийн тухай дэлгэрэнгүй үзэх, Eigen, Das Netz der Korruption: wie eine weltweite Bewegung gegen Bestechung kämpft, S.197, Handbuch „Bestechung und Korruption“ für den Innen- und Außendienst der Steuerverwaltung von OECD, S.14.

¹² Unurmaa, Die Unrechtsvereinbarung als Kern der Korruptionsdelikte, 2014, 6 Teil

мөнгө угаах гэмт хэргийг тусад нь салгаж ойлгон, уг хэргийг шалгах ажиллагааг зэрэг явуулдаггүйгээс авлигын хэрэг үйлдсэн этгээдийн хууль бусаар олсон хөрөнгө, давуу талыг бүрэн олж тогтоолгүй ял шийтгэл оноогоод орхих нь бусад этгээд хууль бусаар хөрөнгөжих боломжийг бий болгож байна. Иймд ялангуяа гаднын улс оронд хөдлөх үл хөдлөх хөрөнгө худалдан авах, дансанд мөнгө байршуулах үйл ажиллагааг хянаж тогтоохын тулд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээтэй болон гэрээгүй орнуудтай Авлигын эсрэг конвенцийн 6 дугаар зүйлд заасны дагуу харьцах, өөр бусад хэлбэрээр хамтран ажиллах боломжийг бүхий л талаар судлан зохион байгуулах талаар конвенцээр хүлээсэн үүргээ биелүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Зөвхөн байгалийн баялаг ашиглуулах, эзэмшүүлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

авлигад автагдахад үндэсний аюулгүй байдалд хэрхэн хортойгоор нөлөөлж болохыг энэхүү илтгэлээр харуулахыг зорилоо.

Байгалийн баялаг дагасан сонирхол, өрсөлдөөнд ямар ч аргаар хамаагүй Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахаар улайрч буй удаа дараагийн оролдлого, өндөр түвшний авлига буюу хууль бус лоббигоор дамжиж эсхүл тодорхой бизнесийг далд аргаар дэмжихэд чиглэгдсэн бодлогоор дамжиж орж ирэх хөрөнгө оруулалт нэртэй хууль бус мөнгөний урсгалыг таслан зогсоох цаад агуулгаараа үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх алхам бол НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж үндэсний хууль тогтоомж тэр тусмаа Эрүүгийн хуульд нэн даруй өөрчлөлт оруулах явдал юм.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УРГАХ